

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2024/196/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл  
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
Аудитор: Х.Манаргүл  
Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## **АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Аудитын гол асуудал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
5.1 Төлбөрийн акт .....	17
5.2 Албан шаардлага .....	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	17

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БАЯННУУР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ДАРГА Е.ЖАНЫЛ ТАНАА

2024.02.22 № 174  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлох үйл явдал гараагүй байна.

**Аудитын гол асуудал**

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402228

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Төгрөгөөр Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>170,635,647.63</u></b>	<b><u>203,567,519.68</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	27,422,561.00	39,659.85
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	27,422,561.00	39,659.85
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	27,422,561.00	39,659.85
31211	Төрийн сангийн харилцах	27,422,561.00	39,659.85
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	19,649,755.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	19,649,755.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	143,213,086.63	183,878,104.83
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	83,526,571.00	102,877,337.00
35130	Эм боох материал	83,526,571.00	102,877,337.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	59,686,515.63	81,000,767.83
35410	Бичиг хэргийн материал	2,603,100.00	1,807,100.00
35420	Аж ахуйн материал	35,719,405.00	61,567,167.50
35440	Түлш, шатах тослох материал	130,000.00	130,000.00
35460	Хүнсний материал	5,667,811.51	3,039,312.21
35470	Бусад хангамжийн материал	15,566,199.12	14,457,188.12
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>970,483,729.32</u></b>	<b><u>972,011,785.26</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	970,483,729.32	972,011,785.26
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	964,715,729.32	966,243,785.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	824,562,603.82	824,562,603.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(77,585,884.74)	(90,938,980.62)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,606,056.00	69,606,056.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(20,260,782.28)	(36,187,726.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	190,634,365.16	211,497,286.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32,532,316.00)	(32,546,116.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,958,128.80	39,094,128.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,766,441.44)	(18,943,466.62)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,601,500.00	5,601,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,601,500.00)	(5,601,500.00)
39217	Ном	100,000.00	100,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	5,768,000.00	5,768,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,768,000.00	5,768,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,141,119,376.95</u></b>	<b><u>1,175,579,304.94</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>257,884.00</u></b>	<b><u>43,976,723.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	257,884.00	43,976,723.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	257,884.00	43,976,723.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	135,484.00	8,128,907.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	122,400.00	35,847,816.00

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41361	Байгууллагад төлөх өглөг	122,400.00	35,184,066.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	663,750.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,140,861,492.95</u></b>	<b><u>1,131,602,581.94</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,140,861,492.95</b>	<b>1,131,602,581.94</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	481,899,043.00	481,899,043.00
51101	Өмч: - төрийн	481,899,043.00	481,899,043.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>216,734,260.24</b>	<b>207,475,349.23</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	216,734,260.24	216,734,260.24
51220	Тайлант үеийн үр дүн	-	(9,258,911.01)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	442,228,189.71	442,228,189.71
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,141,119,376.95</u></b>	<b><u>1,175,579,304.94</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>898,545,292.12</b>	<b>917,949,132.33</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>138,590,432.12</b>	<b>24,295,383.50</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>138,590,432.12</b>	<b>24,295,383.50</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	84,576,271.00	8,329,421.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	54,014,161.12	15,965,962.50
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>759,954,860.00</b>	<b>893,653,748.83</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>310,000.00</b>	<b>-</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	310,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>45,618,500.00</b>	<b>51,060,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,618,500.00	51,060,500.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>714,026,360.00</b>	<b>842,593,248.83</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	714,026,360.00	842,593,248.83
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>719,218,709.70</b>	<b>927,208,043.34</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>719,218,709.70</b>	<b>927,208,043.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>718,450,207.70</b>	<b>926,259,543.34</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>417,797,995.00</b>	<b>580,793,899.00</b>
210101	Үндсэн цалин	414,797,995.00	574,081,496.00
210102	Нэмэгдэл	-	2,512,403.00
210104	Урамшуулал	1,000,000.00	4,200,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,000,000.00	-

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		
		52,687,500.00	74,284,660.98
210201	Тэтгэврийн даатгал	52,687,500.00	74,284,660.98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		
		41,833,748.00	46,954,608.00
210301	Гэрэл, цахилгаан	2,668,248.00	3,950,522.00
210302	Түлш, халаалт	39,165,500.00	43,004,086.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		
		67,593,197.92	64,749,407.00
210401	Бичиг хэрэг	5,020,700.00	6,725,286.00
210402	Тээвэр, шатахуун	53,264,845.92	46,777,483.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,665,500.00	2,507,465.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,221,752.00	6,803,657.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,420,400.00	1,935,516.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		
		101,543,514.04	114,238,263.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	89,614,911.84	100,157,314.00
210502	Хоол, хүнс	10,300,552.20	14,080,949.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,628,050.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		
		12,470,900.00	8,918,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,570,950.00	3,171,000.00
210604	Урсгал засвар	8,899,950.00	5,747,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		
		1,383,500.00	2,183,700.00
210702	Дотоод албан томилолт	1,383,500.00	2,183,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		
		1,178,500.00	492,840.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	330,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	103,160.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,000.00	98,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	214,500.00	198,000.00
210807	Газрын төлбөр	56,000.00	33,680.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		
		21,961,352.74	33,643,765.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,917,460.00	4,172,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,043,892.74	29,470,865.06
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		
		768,502.00	948,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>		
		768,502.00	948,500.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	768,502.00	948,500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>179,326,582.42</b>	<b>(9,258,911.01)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>179,326,582.42</b>	<b>(9,258,911.01)</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>786,554,860.00</u></b>	<b><u>874,003,993.83</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>786,554,860.00</b>	<b>874,003,993.83</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	310,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	310,000.00	
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	45,618,500.00	51,060,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,618,500.00	51,060,500.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	740,626,360.00	822,943,493.83
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	740,626,360.00	822,943,493.83
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>739,140,799.00</u></b>	<b><u>878,717,394.98</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>739,140,799.00</b>	<b>878,717,394.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>738,372,297.00</b>	<b>877,768,894.98</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	422,602,379.00	572,402,636.98
210101	Үндсэн цалин	294,803,479.00	377,486,202.98
210102	Нэмэгдэл	83,245,200.00	125,263,451.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,470,000.00	14,007,000.00
210104	Урамшуулал	30,112,300.00	55,645,983.00
210105	Гэрээт ажлын хөлс	6,971,400.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	52,687,500.00	74,682,500.00
210201	Тэтгэврийн даатгал	35,827,500.00	50,783,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,215,000.00	5,975,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,372,000.00	4,779,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	843,000.00	1,195,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,430,000.00	11,949,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	41,833,748.00	46,954,608.00
210301	Гэрэл, цахилгаан	2,668,248.00	3,950,522.00
210302	Түлш, халаалт	39,165,500.00	43,004,086.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	62,318,500.00	58,682,900.00
210401	Бичиг хэрэг	3,019,600.00	4,550,000.00
210402	Тээвэр, шатахуун	53,280,000.00	46,825,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,665,500.00	2,257,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,512,600.00	2,094,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,840,800.00	2,955,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	123,196,700.00	105,880,618.00

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	108,081,625.00	91,921,057.00
210502	Хоол, хүнс	12,855,275.00	12,264,561.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,259,800.00	1,695,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,601,050.00</b>	<b>8,106,392.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,800,600.00	3,699,000.00
210604	Урсгал засвар	2,800,450.00	4,407,392.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,383,500.00</b>	<b>1,917,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,383,500.00	1,917,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,428,500.00</b>	<b>492,840.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	530,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	103,160.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,000.00	98,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	264,500.00	198,000.00
210807	Газрын төлбөр	56,000.00	33,680.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>23,320,420.00</b>	<b>8,648,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,320,420.00	8,648,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>768,502.00</b>	<b>948,500.00</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>768,502.00</b>	<b>948,500.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	768,502.00	948,500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>47,414,061.00</u></b>	<b><u>(4,713,401.15)</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>19,991,500.00</b>	<b>22,669,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>19,991,500.00</b>	<b>22,669,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>19,991,500.00</b>	<b>22,669,500.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,991,500.00	22,669,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(19,991,500.00)</u></b>	<b><u>(22,669,500.00)</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>≡</b>	<b>≡</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>27,422,561.00</b>	<b>(27,382,901.15)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>27,422,561.00</b>	
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>39,659.85</b>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	481,899,043.00	442,228,189.71	216,734,260.24	1,140,861,492.95
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	481,899,043.00	442,228,189.71	216,734,260.24	1,140,861,492.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	481,899,043.00	442,228,189.71	216,734,260.24	1,140,861,492.95
D08	Тайлант үеийн үр дүн			(9,258,911.01)	(9,258,911.01)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	481,899,043.00	442,228,189.71	207,475,349.23	1,131,602,581.94

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	930,894,600.00	900,438,394.98
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	930,894,600.00	900,438,394.98
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	930,894,600.00	900,438,394.98
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	596,354,600.00	572,402,636.98
210101	Үндсэн цалин	400,244,800.00	377,486,202.98
210102	Нэмэгдэл	115,477,500.00	125,263,451.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,326,000.00	14,007,000.00
210104	Урамшуулал	73,306,300.00	55,645,983.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	74,682,500.00	74,682,500.00
210201	Тэтгэврийн даатгал	50,783,400.00	50,783,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,975,000.00	5,975,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,779,500.00	4,779,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,195,500.00	1,195,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,949,100.00	11,949,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	47,744,500.00	46,954,608.00
210301	Гэрэл, цахилгаан	4,101,000.00	3,950,522.00
210302	Түлш, халаалт	43,643,500.00	43,004,086.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	60,607,800.00	60,607,800.00
210401	Бичиг хэрэг	4,550,000.00	4,550,000.00
210402	Тээвэр, шатахуун	46,825,800.00	46,825,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,257,200.00	2,257,200.00

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,094,000.00	2,094,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,880,800.00	4,880,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>113,397,200.00</b>	<b>107,880,618.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	99,437,600.00	93,921,057.00
210502	Хоол, хүнс	12,264,600.00	12,264,561.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,695,000.00	1,695,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>19,853,600.00</b>	<b>19,694,992.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,287,600.00	14,287,600.00
210604	Урсгал засвар	5,566,000.00	5,407,392.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,917,700.00</b>	<b>1,917,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,917,700.00	1,917,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>532,000.00</b>	<b>492,840.00</b>
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	103,160.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,000.00	98,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,000.00	198,000.00
210807	Газрын төлбөр	56,000.00	33,680.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,804,700.00</b>	<b>15,804,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,804,700.00	15,804,700.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>930,894,600.00</b>	<b>900,438,394.98</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>51,060,500.00</b>	<b>50,112,000.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	51,060,500.00	50,112,000.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>852,411,500.00</b>	<b>822,943,493.83</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	852,411,500.00	822,943,493.83
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>27,422,600.00</b>	<b>27,382,901.15</b>
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	27,422,600.00	27,382,901.15
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>27,422,561.00</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>39,659.85</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>37.00</b>	<b>41.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	27.00	28.00
620003	Үйлчлэх ажилтан	9.00	12.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>37.00</b>	<b>41.00</b>
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	25.00	26.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12.00	15.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тус байгууллагад нэмэлт данс байхгүй байна

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

##### Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Баяннуур сумын Эрүүл мэндийн төв нь үйлчлэх хүрээний хүн амьд эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээг жигд, чирэгдэлгүй, чанартай, хүртээмжтэй үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант онд “байгууллагын бүтэц тогтолцоог оновчтой зохион байгуулж үйл ажиллагааны орчныг боловсонгүй болгох материаллаг баазыг бэхжүүлэх, ард иргэдэд хүлээгдэл, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэх” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Төрөөс эрүүл мэндийн талаарх баримтлах бодлого, үндэсний болон дэд хөтөлбөр, стратеги бүрийн хүрээнд өөрийн байгууллагад хамаарах 9 зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагаанд тусгаж ажилласан байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, төлөвлөгөөний биелэлт 91 хувьтай гарсан байна. Сумын Засаг дарга 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 95 хувиар үнэлсэн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

##### Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Баяннуур сумын Эрүүл мэндийн нь Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

## Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ажилдаа мөрдлөг болгосон байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34.4 сая төгрөгөөр буюу 3.0 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	27,422.6	39.7	(27,382.9)
Авлага	-	19,649.8	19,649.8
Бараа материал	143,213.1	183,878.1	40,665.0
Үндсэн хөрөнгө	970,483.7	972,011.8	1,528.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,141,119.4</b>	<b>1,175,579.3</b>	<b>34,459.9</b>
Өр төлбөр	257.9	43,976.7	43,718.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,140,861.5	1,131,602.6	(9,258.9)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,141,119.4</b>	<b>1,175,579.3</b>	<b>34,459.9</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө 27.3 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлийг зарцуулсантай холбоотой байна.

Авлагын данс 19.6 сая төгрөг болж өссөн нь ЭМД-ын сангаас авах санхүүжилтийн авлага байна.

Бараа материалын данс 40.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 211.8 сая төгрөгийн материал худалдан авч, аймгийн Эрүүл мэндийн газраас үнэгүй 5.5 сая төгрөгийн эм боох материал, 10.4 сая төгрөгийн аж ахуйн материал үнэ төлбөргүй хүлээн авч, үйл ажиллагаанд 181.1 сая төгрөгийн материалыг зарцуулж, 6.0 сая төгрөгийн бараа материалыг акталж устгасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө 1.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 22.7 сая төгрөгийн хөрөнгийн худалдан авч, аймгийн ЭМГазраас 8.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна. Тайлант онд үндсэн хөрөнгөд 29.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант онд -9.2 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 9.2 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр 986.0 сая, нийт зарлагыг 986.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2023 оны төсвийн төслийн саналаас 55.1 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 930.9 сая төгрөгөөр баталсан байна.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны анх батлагдсан төсөв 811.7 сая төгрөг ба тодотгосон төсөв 930.9 сая төгрөг болж анх баталснаас 119.2 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор тайлант оны 7 дугаар сараас цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 852.4 сая, орон нутгийн төсвөөс 51.1 сая, урьд оны үлдэгдлээс 27.4 сая төгрөг бүгд 930.9 сая төгрөгийн орлого санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 822.9 сая, орон нутгийн төсвөөс 51.1 сая төгрөгийн санхүүжилт авч, урьд оны үлдэгдлээс 27.4 сая төгрөг санхүүжүүлж бүгд 901.4 сая орлого санхүүжилтээр ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 900.4 сая төгрөг буюу 96.8 хувьтай байгаа нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг дутуу авсантай холбоотой байна. Харин орон нутгийн төсвөөс хэмнэсэн 0.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нийт төсвийн зарлагын 71.9 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 5.2 хувийг тогтмол зардал, 6.7 хувийг хангамж, бараа материалын зардал, 2.2 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 12.0 хувийг норматив зардал, 1.8 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 0.2 хувийг албан томилолтын зардал эзэлж байна

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
81603	Үндсэн үйл ажиллагааны зардал	571,770.1	547,818.1	(23,952.0)	96%
83603	Харуул, хамгаалалтын зардал	280,641.4	275,085.7	(5,555.7)	98%
80302	Ажил олгогчоос олгох тэтгэмж	27,422.6	27,422.6	(0.0)	100%
80111	Хөтөлбөр төслийн дотоод урсгал	51,060.5	50,112.0	(948.5)	98%
	<b>Дүн</b>	<b>930,894.6</b>	<b>900,438.4</b>	<b>(30,456.2)</b>	<b>97%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн нь 2023 онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баяннуур сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 719.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 10.8 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар 29 арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж үзэхэд алдаа зөрчил илрээгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Баяннуур сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд нийт 942.8 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувь байна. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн 17 шийдвэр байршуулахаас 15-ыг байршуулж нийт хэрэгжилтийн хувь 98.2 хувтай байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн, хяналт дотоод аудитын алба болон сумын Санхүүгийн албанаас шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 114.7 сая төгрөгийн 2 албан шаардлага, 163.9 сая төгрөгийн 2 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	114685.5	2	114685.5	100
Зөвлөмж	2	163918.0	2	163918.0	100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>278603.5</b>	<b>4</b>	<b>278603.5</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорилт хэрэгжүүлсэн бөгөөд төсвийн зарцуулалтыг гүйцэтгэлийн шалгалтаар шалгах шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
							Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
										-			
<b>Дүн</b>										-	-		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<b>Дүн</b>													

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж

Баяннуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
<b>Нийт дүн</b>								